



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 467

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухааны академийн харьяа Геологийн хүрээлэнгийн албан ажлын хэрэгцээнд зориулан 36,000,000.00 (гучин зургаан сая) төгрөгт багтаан автомашин худалдан авахыг зөвшөөрч, техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2. Шинжлэх ухааны академийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Б.Авид, Шинжлэх ухааны академийн харьяа Геологийн хүрээлэнгийн захирал Д.Одгэрэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001304

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт



**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ХАРЬЯА ГЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН
ХУДАЛДАН АВАХ АВТОМАШИН**

Д/д	Автомашины техникийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Худалдан авах үнийн дээд хязгаар
1	Суудлын тоо 10, хөдөлгүүрийн багтаамж 2700 cc /Уаз-220695-550 фургон/	ш	1	36,000,000.00
Нийт дүн			1	36,000,000.00
				(гучин зургаан сая)